



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

┌ Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай ┐

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 138 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өндөрхаан инвест ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн, “Ард капитал групп ҮЦК” ХХК, “Зэргэд ҮЦК” ХХК-иудын арилжаанд оролцох эрхийг 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн тус тус сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг тушаалын 1-д заасан үнэт цаасны компаниудад анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР